

## ГУРАВ: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нүүрс тээврийн ажлын техникийн тодорхойлолт нь техникийн бүрэн бүтэн байдлаар бүрэн илэрхийлэгдэнэ. Нүүрс тээврийн ажлыг гүйцэтгэхдээ техникийн баримт бичгийн үндсэн бүрдэл хэсэг болох Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ачаа тээврийн норм ба дүрэм, стандарт, техникийн нөөцлийг нэг бүрчлэн баримталж ажиллана.

- ❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэгч нь нийт 3-аас доошгүй хөдлөх бүрэлдэхүүнтэй байна.
- ❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэгч нь нийт хөдлөх бүрэлдэхүүний 50 хувиас багагүй нь өөрөө буулгагч байх.
- ❖ Өөрөө буулгах боломжгүй тээврийн хэрэгслийн тээш болон чиргүүл нь ачааг ковшоор түрж буулгаж болдог зориулалтай байх.
- ❖ Түрж буулгах боломжгүй тээш болон чиргүүлд өчсөн ачааг буулгахад гарах зөрдлыг ачаа хүлээн авагч тал хариуцахгүй.
- ❖ Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэх шугаман болон сүлжээ график, санхүүжилтийн хуваарь ирүүлэх.
- ❖ Нүүрс тээвэрлэлтийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн ажиллагааг хангах. Хөдөлмөр хамгаалалт аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн норм дүрэм, стандарт, ажлын байран дахь үзүүлэн таниулах материал, тэмдэг тэмдэглэгээ зайлшгүй байх шаардлагатай.
- ❖ Нүүрс тээврийн ажлыг ачаа тээврийн норм дүрэм, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Нүүрс тээвэрлэлтийн ажил гүйцэтгэгч нь чанар стандартыг хангасан нүүрс ачиж явуулахыг нийлүүлэгч талд тавьж, ашиглалтын шаардлага нийцсэн, элдэв механик хольцгүй нүүрс тээвэрлэх шаардлагатай. Хүлээн авагч тал тээвэрлэж ирсэн нүүрсний дээжийг шинжилж үзээд шаардлагад нийцэхгүй бол хүлээж авахгүй бөгөөд нүүрс буцаахад гарах зөрдалыг хариуцахгүй.

Тендерт шалгарсан тохиолдолд гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, ажил эхлэх, дуусах хугацаа, тээвэр хийх жолооч нарын болон тээврийн хэрэгслийн мэдээлэл зэргийг уг ажил эхлэхээс өмнө захиалагч талд гаргаж өгнө.